



ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар A/38

Бор-Өндөр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.3.1 дэхь хэсгүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Билгийн тооллын 17 дугаар жарны “Элдэв эрдэнэт” хэмээх хөхөгчин мөгийн жилийн сар шинийн баяртай холбогдуулан шаардлага хангаагүй, хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэгдэх хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх, эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, зөрчил дутагдлыг таслан зогсоох зорилгоор Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын хэмжээнд “Хүнсний худалдаа” эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

3.Ууганжаргал

Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Ц.Мөнхгэрэл

Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Б.Болормаа

Мал эмнэлгийн Улсын байцаагч

Р.Цэндсүрэн

Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч

А.Ихэрболд

Хэв журмын асуудал хариуцсан байцаагч, цагдаагийн дэслэгч

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (3.Ууганжаргал), хяналт шалгалтын тайланг 2025 оны 03 дугаар сарын 5-ны өдрийн дотор танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.АДЬЯАБИЛЭГТ



D:/bichig hereg/Zahiramj.docx